

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЯВЦЫН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 06 сарын 06

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхэд чиглэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, хүрсэн түвшинг төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, удаашралтай хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэхэд явцын хяналт-шинжилгээний зорилго оршино.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ДҮГНЭЛТ

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан ажиллав.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1-т заасан арга зүйгээр явцын хяналт шинжилгээ хийхдээ ТЗУХ-ээс ирүүлсэн тайланд үндэслэн хийсэн.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд 05 сарын байдлаар явцын хяналт шинжилгээ хийхэд 46 зорилтын 215 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Зорилтын дундаж 75,4 арга хэмжээний дундаж 65,5 хувьтай, зорилт арга хэмжээний дундаж хувь 70 хувьтай байгаа нь “Эрчимжүүлэх шаардлагатай” байгааг харуулж байна.

Үүнийг хэлтэс, агентлагаар нь задалж харуулбал:

Төрийн захиргааны удирдлагын хэлтэст: 3 зорилтын 14 арга хэмжээ, Онцгой байдлын газарт 1 зорилтын 3 арга хэмжээ тус тус хэрэгжүүлж ажиллаж байна. Нийт 4 зорилтын 17 арга хэмжээний дундаж 73,4 хувьтай байна. Хугацаа

болоогүй 1 зорилт, 1 арга хэмжээ, 50 хувиас доош хэрэгжилттэй 4 арга хэмжээ, 0 хувьтай 1 арга хэмжээ байгааг эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

Хууль эрх зүйн хэлтэст: 2 зорилтын 4 арга хэмжээ, цагдаагийн газарт 2 зорилтын 7 арга хэмжээ, архивын тасаг 2 арга хэмжээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 1 арга хэмжээ, шүүхийн шинжилгээний алба 1 арга хэмжээ, улсын бүртгэлийн хэлтэс 1 арга хэмжээ, шүүх 1 арга хэмжээг тус тус хэрэгжүүлж ажиллаж байна. Нийт 4 зорилтын 17 арга хэмжээний дундаж 75,6 хувьтай байна. Хугацаа болоогүй 3 арга хэмжээ, 0 хувьтай 4 арга хэмжээ байгааг эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

Санхүү, төрийн сангийн хэлтэст: Татварын хэлтэст 1 зорилтын 2 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна. 1 зорилтын 2 арга хэмжээний дундаж 100 хувьтай байна.

Цэргийн штаб: 1 зорилтын 4 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллаж байна. 1 зорилтын 4 арга хэмжээний дундаж 75 хувьтай байна. Хугацаа болоогүй 2 арга хэмжээ, 0 хувьтай 1 арга хэмжээ байгааг эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

Нийгмийн бодлогын хэлтэст: 1 зорилтын 6 арга хэмжээ, Эрүүл мэндийн газарт 6 зорилтын 25 арга хэмжээ, боловсрол шинжлэх ухааны газарт 3 зорилтын 25 арга хэмжээ, Биеийн тамир спортын газарт 1 зорилтын 6 арга хэмжээ, нийгмийн даатгалын хэлтэст 1 зорилт 2 арга хэмжээ, хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 2 зорилтын 8 арга хэмжээ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт 2 зорилтын 5 арга хэмжээ, Соёл урлагийн газарт 3 зорилтын 17 арга хэмжээ тус тус хэрэгжүүлж ажиллаж байна. Нийт 19 зорилтын 94 арга хэмжээний дундаж 77.5 байна. Хугацаа болоогүй 2 зорилт, 29 арга хэмжээ, 50 хувиас доош хэрэгжилттэй 3 зорилт, 13 арга хэмжээ, 0 хувьтай 1 зорилтын 6 арга хэмжээ байгааг эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст: 4 зорилтын 13 арга хэмжээ, Хөдөө аж ахуйн газарт 3 зорилт, 24 арга хэмжээ, Мал эмнэлгийн газарт 1 зорилтын 3 арга хэмжээ, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 7 зорилтын 27 арга хэмжээ, газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 1 зорилтын 12 арга хэмжээ, орон нутгийн өмчийн газарт 1 зорилт 2 арга хэмжээг тус тус хэрэгжүүлж ажиллаж байна. Нийт 17 зорилтын 81 арга хэмжээний дундаж 59,9 хувьтай байна. Хугацаа болоогүй 4 зорилт, 25 арга хэмжээ, 50

